



I-XII/2021

Тархаасан: 2022 оны 1 дүгээр сарын 12




Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого өмнөх оноос 97 тохиолдлоор буурлаа

Мэргэжлийн Хяналтын Ерөнхий Газрын мэдээллээр үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын тохиолдол 2021 оны эцэст 256 бүртгэгдэж, өмнөх оны мөн үеэс 97 (27.5%)-оор буурсан бол 2021 оны 4 дүгээр улиралд 85 тохиолдол бүртгэгдэж өмнөх улирлаас 29 (51.8%) -өөр өссөн байна.

Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын 82 (32.0%) тохиолдол унасан, бүдэрсэн, хальтирснаас үүссэн бол эд зүйлд хавчуулагдсан 32 (12.5%), унаж байгаа эд зүйлд цохигдсон 28 (10.9%), гадны халдлагад өртсөн 16 (6.3%), хүчилсэн болон хүчтэй хөдөлгөөнд өртсөн 11 (4.3%), эд зүйл дээр гишгэсэн суурин болон хөдөлгөөнт эд зүйлд цохигдсон 10 (3.9%), халсан, түлэгдсэн, хөлдсөн 10 (3.9%), цахилгаан гүйдэлд цохиулсан 9 (3.5%), живсэн 3 (1.2%), хорт бодис, цацраг идэвхийн нөлөөнд өртсөн 1 (0.4%), бусад 54 (21.1%) тохиолдол бүртгэгдсэн байна.


Нийт осолдогчдын 110 (43.0%) нь хөнгөн хэлбэрээр, 112 (43.8%) нь хүнд хэлбэрээр осолдож, 34 (13.3%) хүн нас барсан байна.

ЗУРАГ 1. ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ, ХУРЦ ХОРДЛОГО, бүсээр, жил бүрийн эцэст



Нийт осолдогчдын 65 (25.4%) нь эмэгтэйчүүд байна. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын тохиолдол 2021 онд Баруун бүсэд 21 (8.2%), Хангайн бүсэд 14 (5.5%), Төвийн бүсэд 58 (22.7%), Зүүн бүсэд 25 (9.8%), Улаанбаатар хотод 130 (50.8%), бусад буюу Улаанбаатар төмөр замд 8 (3.0%) бүртгэгдсэн байна.

ЗУРАГ 2. ОСОЛДОГЧИД, насны бүлгээр,
дүнд эзлэх хувиар, 2021




Осолдогчдыг насны бүлгээр авч үзэхэд 14 хүртэлх насны 3 (1.2%), 18-24 насны 39 (15.2%), 25-34 насны 81 (31.6%), 35-44 насны 61 (23.8%), 45-59 насны 67 (26.2%), 60, түүнээс дээш насны 5 (2.0%) байна.

ХҮСНЭГТ 1.ОСОЛДОГЧИД, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар, жил бүрийн эцэст

Салбар	2019	2020	2021
Дүн	336	353	256
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	3	6	9
Уул уурхай, олборлолт	80	73	34
Боловсруулах үйлдвэрлэл	24	36	31
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	12	7	6
Усан хангамж, бохир ус зайлуулах систем, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	23	5	9
Барилга	38	43	21
Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээ	8	8	9
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	39	44	18
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	11	3	7
Мэдээлэл, холбоо	5	4	4
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	10	6	1
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	-	-	1
Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	3	3	1
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	-	-	3
Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	22	53	45
Боловсрол	14	14	3
Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа	16	24	25
Урлаг, үзвэр, тоглоом наадам	1	1	-
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	27	23	29

Нийт осолдогчдыг эрхэлж байсан ажил мэргэжлээр нь авч үзвэл, энгийн ажил мэргэжилтэй хүн 83 (32.4%), үйлдвэрлэл, барилга, гар урлалтай, холбоотой ажил, үйлчилгээний ажилтан 41 (16.0%), зэвсэгт хүчний ажилтан, мэргэжилтэн 32 (12.5%), суурин төхөөрөг, машин механизмын операторч, угсрагч 29 (11.3%), техникч болон туслах, дэд мэргэжилтэн 26 (10.2%), мэргэжилтэн 17 (6.6%), контор, үйлчилгээний ажилтан 12 (4.7%), худалдаа үйлчилгээний ажилтан 9 (3.5%), менежер 4 (1.6%), ХАА, ой загас агнуурын мэргэшсэн ажилтан 3 (1.2%) байна.

ЗУРАГ 3. ОСОЛДОГЧИД, ажил мэргэжлийн ангиллаар, дүнд эзлэх хувиар, 2021



- Энгийн ажил, мэргэжил
- Зэвсэгт хүчний ажилтан, мэргэжилтэн
- Үйлдвэрлэл, барилга, гар урлалтай, холбоотой ажил, үйлчилгээний ажилтан
- Техникч болон туслах, дэд мэргэжилтэн
- Суурин төхөөрөг, машин механизмын операторч, угсрагч
- Мэргэжилтэн
- Бусад

Ойлголт, тодорхойлолт:

Үйлдвэрлэлийн осол гэж хөдөлмөр эрхлэгч иргэн хөдөлмөрлөх үүргээ биелүүлэх явцад үйлдвэрлэлийн болон түүнтэй адилтгах хүчин зүйлийн үйлчлэлд өртөхийг ойлгоно.

Хурц хордлого гэж цацраг болон биологийн идэвхт бодис, химийн хорт бодисын нөлөөгөөр хурц, цочмог хэлбэрээр богино хугацаанд хордохыг ойлгоно.

Осолдогч гэж үйлдвэрлэлийн осол, хурц хордлогод өртсөн ажилтан, иргэнийг ойлгоно.

Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогод өртсөн нэг ажилтан, иргэнийг үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын нэг тохиолдол гэж үзнэ.

Хэрвээ нэг осол, хордлогод нэгээс дээш тооны хүн өртсөн бол осолдогч тус бүрээр үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын тохиолдол гэж тооцно.

Бүлэг осол, хурц хордлого гэж нэг үйлдвэрлэлийн осол, хурц хордлогод 2, түүнээс дээш тооны ажилтан, иргэн өртөхийг ойлгоно.



Эх үүсвэр:

Мэргэжлийн Хяналтын Ерөнхий Газар

Ангилал, код:

ISCO-08 Ажил, мэргэжлийн ангилал, Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал, ICD-10 өвчний олон улсын ангилал

Мэдээлэл авах холбоос:

<http://www.nso.mn/>
<http://www.1212.mn/>

Дараагийн мэдээ тархаах хуваарь:

2022 оны 4 дүгээр сарын 13

Нийгмийн статистикийн газар,
Өрхөд суурилсан судалгааны хэлтсийн
статистикч Н. Алтантүлхүүр
Утас : (976-51)-265543

Нийгмийн статистикийн газрын
дарга А.Амарбал
Утас : (976-51)-264805



/StatisticMGL



information@nso.mn



1900-1212